

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/12/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг Төрийн Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Отгонбаяр
Утас: 89306788 Цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ИдБ. 03.27 № 01/296
танай _____-ны № _____-т

РЕНЧИНЛХҮМБЭ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Д.ОТГОНБАЯР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Рэнчинлхүмбэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рэнчинлхүмбэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлснээр хөрөнгө 3,370.5 сая төгрөгөөр буюу 59.4 хувиар буурсан байна.

Аудитын гол асуудал

Улс, аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогоос 7 нэр төрлийн 30.3 сая төгрөгийн орлого тасарсан, Хоршоо хөгжүүлэх сангийн богино хугацаат зээлийн авлагын үлдэгдэл 15.2 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Рэнчинлхүмбэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Хөвсгөл аймгийн Засаг даргатай тайлант онд 7 чиглэлээр 74 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 97.4 хувиар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.27 № 01/296
танай _____-ны № _____-т

РЕНЧИНЛХҮМБЭ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Д.ОТГОНБАЯР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Рэнчинлхүмбэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рэнчинлхүмбэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлснээр хөрөнгө 3,370.5 сая төгрөгөөр буюу 59.4 хувиар буурсан байна.

Аудитын гол асуудал

Улс, аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогоос 7 нэр төрлийн 30.3 сая төгрөгийн орлого тасарсан, Хоршоо хөгжүүлэх сангийн богино хугацаат зээлийн авлагын үлдэгдэл 15.2 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Рэнчинлхүмбэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Хөвсгөл аймгийн Засаг даргатай тайлант онд 7 чиглэлээр 74 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 97.4 хувиар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,208,323.3	1,228,010.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	448,042.4	1,045,394.1
33	АВЛАГА	132,695.3	96,055.6
35	БАРАА МАТЕРИАЛ	627,585.6	86,560.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,467,340.2	1,640,912.9
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	75,666.7	138,825.0
37300	Урт хугацаат зээл	75,666.7	138,825.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,391,673.5	1,502,087.9
39200	Биет хөрөнгө	4,036,408.5	1,341,597.9
39300	Биет бус хөрөнгө	355,265.0	160,490.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,675,663.5	2,868,923.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,031.1	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,031.1	0.0
41300	Өглөг	2,031.1	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,673,632.4	2,868,923.5
51	Засгийн газрын хувь оролцоо	5,673,632.4	2,868,923.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,824,605.1	871,793.2
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,824,605.1	871,793.2
51200	Хуримтлагдсан үр дүн	1,786,204.4	1,666,224.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,062,822.9	330,906.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,675,663.5	2,868,923.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,079,087.7	1,942,484.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	276,700.7	1,172,551.1
110	Орлогын албан татвар	155,409.9	858,895.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	155,409.9	867,326.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-8,431.4
113	Хөрөнгийн албан татвар	38,072.2	87,414.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,218.7	226,241.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	948,482.7	47,459.1
120	Нийтлэг татварын бус орлого	948,482.7	47,459.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,853,904.3	722,474.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,300,721.1	1,301,244.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,300,721.1	1,301,244.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,479,685.4	1,022,037.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,091,387.8	426,809.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	276,110.8	52,977.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,058.4	120,651.6
2104	Хангамж, бараа материалын зардал	145,114.0	103,820.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,961.6	23,410.5
2107	Томилолт, зочны зардал	6,684.0	5,040.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,408.4	37,593.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	378,429.1	251,735.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	821,035.8	279,207.4

Ренчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	778,366.6	641,239.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	225,774.8	3,371,129.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	552,591.8	-2,729,889.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,151,269.9	1,952,443.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	276,700.7	1,172,551.1
110	Орлогын албан татвар	155,409.9	858,895.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	155,409.9	867,326.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-8,431.4
113	Хөрөнгийн албан татвар	38,072.2	87,414.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,218.7	226,241.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,235.8	44,677.6
1181	Газрын төлбөр	363.1	29,800.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	72,619.8	151,764.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,271.0	58,663.6
120	Нийтлэг татварын бус орлого	74,271.0	58,663.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,800,298.2	721,228.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,736,579.2	1,202,085.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,736,579.2	1,202,085.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,915,543.4	786,381.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,088,807.0	427,096.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	278,006.0	52,553.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,494.4	125,398.9
2104	Хангамж, бараа материалын зардал	134,227.5	83,402.3
2105	Нормативт зардал	153,288.8	2,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,123.4	23,470.5
2107	Томилот, зочны зардал	6,684.0	5,040.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,318.8	39,804.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,593.5	27,015.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	821,035.8	415,704.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	414,690.7	750,357.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	329,868.1	13,306.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	329,868.1	13,306.3
2200	Дотоод эх үүсвэрээр	329,868.1	13,306.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-329,868.1	-13,306.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-50,000.0	-139,700.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,000.0	139,700.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	34,822.6	597,351.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	413,219.9	448,042.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	448,042.4	1,045,394.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,121,040.7	0.0	5,121,040.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	36,973.2	0.0	36,973.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,158,013.8	0.0	5,158,013.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-36,973.2	0.0	-36,973.2
9	Тайлант үеийн үр дүн	552,591.8	0.0	552,591.8
10	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,673,632.4	0.0	5,673,632.4
11	2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	5,673,632.4	0.0	5,673,632.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-74,819.5	0.0	-74,819.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,598,812.9	0.0	5,598,812.9
19	Тайлант үеийн үр дүн	-2,729,889.4	0.0	-2,729,889.4
20	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,868,923.5	0.0	2,868,923.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт, хэмнэлт +,-	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,648,919.10	1,288,783.87	-360,135.23	78.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,502,710.10	1,149,083.87	-353,626.23	76.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	774,410.20	761,169.97	-13,240.23	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432,996.40	427,096.02	-5,900.38	98.6
210101	Үндсэн цалин	345,226.50	333,552.48	-11,674.02	96.6
210102	Нэмэгдэл	73,292.40	80,266.01	6,973.61	109.5
210104	Урамшуулал	14,477.50	13,277.53	-1,199.97	91.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,569.40	52,553.34	-2,016.06	96.3
210201	Тэтгэврийн даатгал	37,713.90	36,431.22	-1,282.68	96.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,214.00	4,148.90	-65.10	98.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,371.00	3,160.71	-210.29	93.8
210204	Ажилгүйдлийн даатгал	842.90	886.89	43.99	105.2
210205	Эрүүл мэндийн даатгал	8,427.60	7,925.63	-501.97	94.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,777.80	125,398.92	-378.88	99.7
210301	Гэрэл, цахилгаан	25,380.40	25,123.99	-256.41	99.0
210302	Түлш, халаалт	90,504.80	92,256.33	1,751.53	101.9
210303	Цэвэр, бохир ус	9,892.60	8,018.61	-1,873.99	81.1
2104	Хангамж, бараа материалын зардал	57,766.50	57,346.91	-419.59	99.3
210401	Бичиг хэрэг	6,800.00	6,596.49	-203.51	97.0
210402	Тээвэр, шатахуун	40,727.30	40,685.40	-41.90	99.9

**Ренчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 413.00	2,478.67	65.67	102.7
210404	Ном, хэвлэл	170.00	0.00	-170.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2 100.00	2,100.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5 556.20	5 486.35	-69.85	98.7
2105	Норматив зардал	2,600.00	2,600.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2 600.00	2,600.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,778.20	36,776.79	-1.41	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	13 306.30	13,306.30	0.00	100.0
210604	Урсгал засвар	23 471.90	23,470.49	-1.41	100.0
2107	Томилолт, зочны зардал	5,604.10	5,040.00	-564.10	89.9
210702	Дотоод албан томилолт	5 604.10	5,040.00	-564.10	89.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,617.80	27,342.69	-3,275.11	89.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28 709.60	25,675.57	-3,034.03	89.4
210803	Даатгалын үйлчилгээ	264.20	264.20	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157.00	156.49	-0.51	99.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	57.00	56.77	-0.23	99.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1 230.00	1,113.50	-116.50	90.5
210807	Газрын төлбөр	200.00	76.16	-123.84	38.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,700.00	27,015.30	-684.70	97.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23 000.00	22,990.70	-9.30	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4 700.00	4,024.60	-675.40	85.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	728,299.90	387,913.90	-340,386.00	53.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	643,617.90	303,301.90	-340,316.00	47.1
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	643 617.90	303,301.90	-340,316.00	47.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,682.00	84,612.00	-70.00	99.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1 300.00	1,280.00	-20.00	98.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27 433.20	27,433.20	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,798.80	55,798.80	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150.00	100.00	-50.00	66.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	146 209.00	139,700.00	-6,509.00	95.5
230001	Эргэж төлөгдөх зээл	146 209.00	139,700.00	-6,509.00	95.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,648,919.10	1,306,102.86	-342,816.24	79.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	235,089.70	235,089.70	0.00	100.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	235 089.70	235,089.70	0.00	100.0

Ренчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	931,006.30	1,016,884.57	85,878.27	109.2
320001	Орон нутгийн төсвөөс	931,006.30	1,016,884.57	85,878.27	109.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	482,823.10	54,128.59	-428,694.51	11.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	145,609.00	52,136.38	-93,472.62	35.8
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200.00	1,992.21	792.21	166.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	336,014.10	0.00	-336,014.10	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		301,773.9		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		319,092.9		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,840.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,840.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,517.52
2104	Хангамж, бараа материалын зардал	26,055.43
210401	Бичиг хэрэг	553.00
210402	Тээвэр, шатахуун	25,502.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,462.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,462.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,322.82
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	12,943.34
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	12,943.34
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,214.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,214.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,164.98
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,164.98
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	46,897.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,897.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,627.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,270.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-12,943.34
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,943.34
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Ренчинлхүмбэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Ренчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байр, иргэдийн орлого нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжинэ” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Ренчинлхүмбэ сумын засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 86.5 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй. Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагуудын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль улсын төсөвт, Соёлын төв болон Эрүүл мэндийн төв нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу тус тус улсын төсөвт шилжсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас нэгдсэн байдлаар боловсруулан мөрдүүлж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд томоохон өөрчлөлт ороогүй байна. Тайлант онд шинээр Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлсэн.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Сумын засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/24 тоот захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна. Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх 7 ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын хөрөнгө материалын ашиглалт, орон нутгийн орлогын төлөвлөгөө, байгууллагын дотоод хяналтын багийн ажлын хэрэгжилт, дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэн гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан хэдий ч үр дүнг тооцож илэрсэн зөрчлийг арилгасан эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын нэгжийн гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын нэгжээс шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ренчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-д нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ. Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ренчинлхүмбэ сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,806.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	448.0	1045.4	597.4
Авлага	132.7	96.0	-36.7
Бараа материал	627.6	86.6	-541.0
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,208.3	1,228.0	19.7
Урт хугацаат хөрөнгө оруулалт	75.7	138.8	63.1
Үндсэн хөрөнгө	4,391.7	1,502.1	-2889.6
Нийт хөрөнгө	5675.7	2868.9	-2806.8
Өр төлбөр	2.0	0	-2.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5673.6	2868.9	2804.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5675.7	2868.9	-2806.8

Эх сурвалж: Ренчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө, бараа материал, засгийн газрын хувь оролцоо, өр төлбөр данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 597.4 сая төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн үлдэгдэл урд оноос 103.5 сая төгрөгөөр, сумын орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл өмнөх оноос 594.2 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.
- Авлага данс 36.7 сая төгрөгөөр өмнөх оноос буурч 96.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба үүнээс Хоршоо хөгжүүлсэн сангийн азлагын үлдэгдэл 96.0 сая төгрөг байна. Үүнээс 2 иргэнтэй холбоотой 15.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 550.7 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль 300.9 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэгүүд 109.8 сая төгрөг, соёлын төв 17.2 сая төгрөг, эрүүл мэндийн төв 122.8 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлсэн байна.
- Урт хугацаат зээл 63.1 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас 139.7 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэн сангийн 1 жилээс дээш хугацааны дараа төлөгдөх зээлийн үлдэгдэл юм.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,819.7 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд: Соёлын төвийн 273.4 сая төгрөг, Ерөнхий боловсрол сургуулийн 1,540.9 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн 421.5 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн 583.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотойгоор буурсан байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,942.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 4,136.6 сая төгрөгөөр буюу 81.4 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	276.7	1,172.6	895.9	323.7
Татварын бус орлого	948.5	47.5	-901.0	-94.9
Тусламж санхүүжилтийн орлого	3,353.9	722.4	-3,131.5	81.2
Нийт дүн	5,079.1	1,942.5	-4,136.6	-81.4

Эх сурвалж: Ренчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, санхүүжилтийн орлого зэрэг нь нөлөөлсөн байна. Мөн татварын орлого өссөн нь орон нутгийн орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 1,156.4 сая төгрөгийн орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 4,672.3 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №3 Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	4,300.7	1,301.2	-2,999.5	-69.7
Үйл ажиллагааны бус зардал	225.8	3,371.1	3,145.3	1,392.9
Нийт дүн	4,526.5	4,672.3	145.8	3.2

Эх сурвалж: Ренчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт зардлын дүн өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалыг шилжүүлэхдээ үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 1,156.4 сая төгрөгийн зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Рэнчинлхүмбэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 12 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,648.9 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Нийт зардлын 235.1 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 439.2 сая төгрөгийг аймгийн санхүүгийн дэмжлэгээс, 491.8 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 146.8 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, давсан орлого дансны үлдэгдлээс 336.0 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Рэнчинлхүмбэ сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор төсөвт 104.5 сая төгрөгөөр нэмэх тодотгол хийж төсвийг 1,648.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Рэнчинлхүмбэ сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэгийг 142.2 сая

төгрөгийн хасах тодотгол хийж төсвийг 439.2 сая төгрөгөөр баталсан байна. Тогтоолын 2 дугаар хавсралтаар орон нутгийн ерөнхий орлогын дансны буюу 2021 оны давсан орлого 77.9 сая төгрөг, 2022 оны орон нутгийн орлогын татварыг 38.2 сая төгрөг нэмж баталсан.

Хасах тодотгол хийсэн нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагад ажиллагсдын цалинг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Гүйцэтгэлээр мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 301.8 сая төгрөг дээр орон нутгийн төсвийн санхүүжилт 1,030.2 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 52.1 сая төгрөг, хүүгийн эргэн төлөлт 2.0 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 235.1 сая төгрөгийн санхүүжилтийн орлого орж, 1,288.8 сая төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 13.3 сая төгрөг төвлөрүүлж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 319.1 сая төгрөг байна. Төсвийн орлого бүрдүүлэлтийг харуулбал:

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Рэнчинлхүмбэ сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 09 дүгээр тогтоолд зааснаар Рэнчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 442.3 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 1,121.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 253.4 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	160.0	179.2	19.2	112.0
Үйл ажиллагааны орлого	12.8	38.9	26.1	303.4
Хөрөнгийн орлого	45.0	43.8	-1.2	97.3
Хөрөнгө борлуулсны орлого	3.1	2.6	-0.5	83.0
Шууд бус орлого	4.8	602.9	598.1	12560.4
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	8.5	8.4	-0.1	99.2
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	8.1	7.3	-0.8	89.3
Бууны албан татвар	2.7	1.9	-0.8	68.8
Малын тоо толгойн албан татвар	100.0	78.2	-21.8	78.2
Улсын тэмдэгтийн хураамж	14.0	40.1	26.1	286.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.7	0.8	0.1	111.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2.1	3.8	1.7	180.0
Газрын төлбөр	5.7	5.7	0	100.0
Дуудлага худалдаа	20.5	24.1	3.6	117.8
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	45.8	75.1	29.3	163.8
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.9	0.8	-0.1	84.3
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.5	0.3	-0.2	68.2
Торгуулийн орлого	4.0	4.5	0.5	113.4
Түрээсийн орлого				
НИЙТ ОРЛОГО	442.3	1,121.0	678.7	253.4

Эх сурвалж: Рэнчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Рэнчинлхүмбэ сумын орон нутгийн орлого 678.7 сая төгрөгөөр давж биелэхэд цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын татвар 19.2 сая төгрөг, 2021 оны ноос, ноолуурын урамшууллын орлогоос хувь хүний орлогын орлогын албан татвар суутгаж, нөхөн төлүүлснээр үйл ажиллагааны орлого 26.1 сая төгрөг, Шууд бус орлогын татварт акт тавигдаж, актын төлбөрийг барагдуулж 598.1 сая төгрөг, Улсын тэмдэгтийн орлогод Спорт агнуурын зөвшөөрлийн хураамжаар 26,1 сая төгрөг, Хог хаягдлын хураамжийн төлбөрийн 2021 оны дутууг төлүүлснээр 1.7 сая төгрөг, Ан, амьтны нөөц ашигласны төлбөрт спорт агнуурын зөвшөөрлийн хураамжийн орлогоос 29.3 сая төгрөг, Газрын дуудлага худалдааны орлого 3.6 сая төгрөгөөр, хяналт шалгалтын үр дүнгээс хамааран торгуулийн орлого 0.5 сая төгрөгөөр тус тус нөлөөлсөн байна.

Орон нутгийн тасарсан орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Хөрөнгийн орлого 1.2 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 0.5 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 0.8 сая төгрөг, Бууны албан татвар 0.8 сая төгрөг, Малд ноогдуулах албан татварын 21.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн орлогоос 5 нэр төрлийн орлого төлөвлөснөөс 25.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 19.9 сая төгрөгөөр төлөвлөж 25.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 27.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №05: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ААНОАТ	2.7	0	-2.7	0
2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	13.0	22.2	9.2	170.7
3	Зам ашигласны төлбөр	2.6	3.2	0.6	123.1
4	Түрээсийн орлого	1.6	0	-1.6	0
	Нийт дүн	19.9	25.4	5.5	127.6

Эх сурвалж: Ренчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар 9.2 сая төгрөгийг давж биелүүлсэн байна.

ААНОАТ, түрээсийн орлого тасарсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 8.9 сая төгрөгөөр төлөвлөж 9.0 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 0.01 сая төгрөгөөр буюу 1 хувиар давуулж биелүүлсэн байна.

Хүснэгт №06: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	3.5	1.0	-2.5
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	5.3	5.9	0.6
3	Агаарын бохирдлын төлбөр	0.7	2.1	1.4
	Нийт дүн	8.9	9.0	0.1

Эх сурвалж: Ренчинлхүмбэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 2.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 1,648.9 сая төгрөгөөр төлөвлөж, 1,306.1 сая төгрөг буюу 79.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 146.8 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 54.1 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,648.9 сая төгрөг, аймгийн төсөвт давсан орлогоос 11.6 сая төгрөг, нийт 1,660.5 сая төгрөгөөр төсвийн зарлагыг баталсан байна. Үүнээс 870.7 сая төгрөгийг урсгал зардалд, 643.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 146.2 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Төсвийн зарлагыг гүйцэтгэлээр урсгал зардалд 845.8 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 303.3 сая төгрөгийг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд 139.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1.288.8 сая төгрөг буюу 78.2 хувьтай байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 5.9 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 0.4 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 3.0 сая төгрөг

- Бараа үйлчилгээний бусад зардал 0.7 сая төгрөг
- Урсгал шилжүүлэг 340.3 сая төгрөгийг тус тус хэмнэгдсэн байна.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 35 төсөл арга хэмжээнд 643.6 сая төгрөг батлагдсанаас 23 төсөл арга хэмжээнд 303.3 сая төгрөгийг зарцуулж хэрэгжээгүй 12 төсөл арга хэмжээний 317.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансны эхний үлдэгдэл 12.9 сая төгрөг байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад дээд шатны төсөв захирагчаас 26.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 20.3 сая төгрөг нийт 46.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 59.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Ренчинлхүмбэ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 01/39 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,285.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 25.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 20.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой горим сорил хэрэгжүүлэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ренчинлхүмбэ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд 3 зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	-	3	-	100
Нийт дүн	3	-	3	-	100

Өмнөх онд тогтоосон 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ренчинлхүмбэ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд 3 зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	-	3	-	100
Нийт дүн	3	-	3	-	100

Өмнөх онд тогтоосон 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажигласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн. Тайлант онд боловсролын, соёл, эрүүл мэндийн салбарын 4 байгууллага улсын төсөвт шилжсэн тул хаалтын тайлан гаргаж нэгтгэсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 45.5 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрсэн. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой 1, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой 1, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, зөвлөмж хүргүүлээгүй нийт 2 зөвлөмж хүргүүлж байна.

Залруулсан алдааны талаар: Тайланд залруулга хийгдээгүй болно.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын зөрчлийн талаар:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилтэй асуудал илрээгүй байна.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогүй байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Татварын орлогын төлөвлөгөөнөөс 7 нэр төрлийн 30.3 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс, аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр ханган биелүүлж ажиллах.

2. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн богино хугацаат авлагын үлдэгдэл 96.0 сая төгрөг байна. Үүнээс 2 иргэний 15.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоо хөгжүүлэх сангийн журам"-ын 3.4.11.Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хоцорсон зээл, хүүгийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

3. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар

3.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилтэй асуудал илрээгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хоршоо хөгжүүлэх сангийн богино хугацаат авлагын үлдэгдэл 96.0 сая төгрөг байна. Үүнээс хугацаа хэтэрсэн авлагын 15.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.	1	15.2					1	15.2				
Орон нутгийн орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн	1	30.3					1	30.3				
Дүн	2	45.5						45.5				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Дүн												

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ:

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Д.ОТГОНБАЯР ОГНОО: 2023.03.25